# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ

# ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

## Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим

хүнлэг, энэрэнгүй байх
үнэнч, шударга байх

хариуцлагатай байх
манлайлах
хамтач байх

## Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээ



- Ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх
- Зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
- Хууль ёс, шударга ёсыг дээдлэн сахих, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- Албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх;
- Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн хувьд төвийг сахиж, аливаа улс төрийн эвсэл, хөдөлгөөн, намын нөлөөллөөс ангид байх;
- Төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх;




- Албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх;

- Байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх;

- Албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх;

- Багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах.

## Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага

- Иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх;
- Эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг баримтлах;
- Бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй байх, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх;
- Бусдын ажил хэрэгч саналыг үл хайхрах, мушгин гуйвуулахгүй байх, худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;
- Бусдын өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарлахгүй байх;
- Албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс, жаягийг чанд баримтлах, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх;
- Албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй байх.



# Төрийн албан хаагчийн үнэт зүйл





- Шударга байдлыг эрхэмлэх;
- Үр ашигтай ажиллах;
- Хариуцлагатай байх;
- Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- Харилцан хүндлэлтэй соёлтой харилцааг эрхэмлэх;
- Төлөвлөсөндөө хүрэх, Цагийн менежмент сайтай ажиллах;
- Бусдыг ойлгох, энэрэнгүй хандах.

## Ажлын байрны ёс зүй гэж юу вэ?

### Байгууллагын соёл,
### үнэт зүйлийг тодорхойлох


- **Ажилтны зан төлөвийг чиглүүлэхийн тулд тухайн байгууллагын соёл, үнэт зүйл тодорхой байх**


### Байгууллагын стандартыг
### мөрдөж хэвшүүлэх

- **Ёс зүйн асуудлыг шийдвэрлэх хүлээн зөвшөөрөгдөх зан авир, дүрэм журмыг тодорхойлсон нарийвчилсан код /стандарт/-ыг боловсруулах.**

### Хүртээмжтэй, ил тод байдлыг
### хангах

- **Байгууллагын үнэт зүйл, соёлыг бүх ажилтнуудад таниулах, ойлгуулахад анхаарах**







# Ажлын байрны ёс зүйг баримтлахад удирдлагын үүрэг

## Ажлын байрны ёс зүйг баримтлахад удирдлагын үүрэг

Ёс зүйн удирдлага нь ажилтнуудын дунд зарчимч байдал, хариуцлага, хүндэтгэлийг дэмждэг жишгүүдийг бий болгосноор байгууллагын ерөнхий соёлыг төлөвшүүлдэг

## Зан төлөвийн жишиг тогтоох нь

Удирдагч, манлайлагч өөрийн үйлдэлдээ хариуцлагатай хандаж, аливаа гаргасан шийдвэр нь албан хаагчид хүлээн зөвшөөрсөн байдлыг бий болгох.

## Итгэлцлийг бий болгох нь

Удирдагч, манлайлагч гишүүдийн итгэлийг нэмэгдүүлэхийн тухайд байгууллага дотроо илэн далангүй харилцааг дэмждэг.

## Ёс зүйн шийдвэр гаргахыг урамшуулан дэмжих нь

Удирдагчид ёс зүйн шийдвэр гаргахыг эн тэргүүнд тавих орчинг бүрдүүлэх

- Ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээ
- Зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хэм хэмжээ
- Хууль ёс, шударга ёсыг дээдлэн сахих, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ёс зүйн хэм хэмжээ
- Албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх ёс зүйн хэм хэмжээ



Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоол

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоол

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ



- Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн хувьд төвийг сахиж, аливаа улс төрийн эвсэл, хөдөлгөөн, намын нөлөөллөөс ангид байх ёс зүйн хэм хэмжээ
- Төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх ёс зүйн хэм хэмжээ
- Албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх ёс хэм хэмжээ
- Байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх ёс зүйн хэм хэмжээ
- Албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх ёс зүйн хэм хэмжээ
- Багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах ёс зүйн хэм хэмжээ

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 02 өдөр Дугаар 109 Улаанбаатар хот

Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г хавсралт ёсоор батлуулсугай.

2.Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар батлуулсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ

Удирдах албан тушаалтан Та :

Хууль, ёс зүйн хэмжээний хүрээнд шийдвэр гаргаж, бусдыг үлгэрлэн манлайлдаг.

Хэм хэмжээ тодорхой бус байх эсвэл албан хаагчийн үнэт зүйлстэй зөрчилдөх үед шийдвэр гаргахад хэцүү байдаг.

Төрийн үнэ цэнэ нь төрийн албан хаагчдын удирдах, гүйцэтгэх ёс суртахуун дээр тогтдог.





*ЁС ЗҮЙ БОЛ ХҮН ЮУ ХИЙХ ЭРХТЭЙ БОЛОН ЮУ ХИЙХ НЬ ЗӨВ БОЛОХЫН ЯЛГААГ МЭДЭХИЙГ ХЭЛНЭ.*

*АНУ-ын Дээд шүүхийн шүүгч Поттер Стюарт*



# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ

# ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

2024 ОН